



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 14 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 14 дүгээр хуралдаан 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 14 дүгээр хуралдаанаар /2025-06-27/ "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын холбогдох хэсгийг хүчингүй болгох тухай (Хорооны 2023 оны 106 тоот тогтоол); "Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг" баталсан (Хорооны 2020 оны 90 тоот тогтоол) тогтоол цуцлах тухай; Сонгон шалгаруулалтын эрхийн төлбөрийн хэмжээ тогтоох тухай (Хорооны 2021 оны 26 тоот тогтоол) тогтоолыг цуцлах тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, тусгай зөвшөөрөл дугаарлалтын хугацаа сунгах тухай болгох тухай үнэлгээ, дүгнэлт болон Бүртгэлийн гэрчилгээ хүчингүй болгох тухай, Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 11 (Тогтоол №139-149, 2025-06-27) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 106 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын 4.5, 4.3-ын хүснэгт-2, 4.8-ын хүснэгт-3 тус тус хүчингүй болгуулах нэхэмжлэлийг "Ондо ХХК"-иас гаргасан. Энэхүү нэхэмжлэлийг Захиргааны хэргийн давж заалдах шүүхийн 2024 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024.08.02-ны өдрийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагуудыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн (Үүнд: нэгдүгээрт, Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын 4.5 дахь хэсгийг хүчингүй болгох шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн; хоёрт, "4.3-ын хүснэгт-2, 4.8-ын хүснэгт-3 тус тус хүчингүй болгуулах" нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох). Улмаар, Монгол Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн тогтоолоор нэгдүгээр заалтаар, Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын 4.5 дахь хэсгийг хүчингүй болгож; мөн хоёрдугаар заалтаар, "4.3-ын хүснэгт-2, 4.8-ын хүснэгт-3 тус тус хүчингүй болгуулах" нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгон тус тус шийдвэрлэсэн. Иймээс хорооны 2025 оны ээлжит 14 дүгээр хуралдаанд Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүхийн 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор тус хорооны ЗУХАГ, Хуулийн хэлтсээс "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын холбогдох хэсгийг хүчингүй болгох тухай (Хорооны 2023 оны 106 тоот тогтоол)

танилцуулга, шүүхийн шийдвэр, хуулийн үндэслэл, тогтоолын төслийг тус тус боловсруулан хэлэлцүүлэв. Тус хуралдаанаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 127 дугаар зүйлийн 127.5, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 001/ХТ2024/0117 дугаар тогтоолыг тус тус үндэслэн "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын холбогдох хэсгийг хүчингүй болгох тухай 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 139 тоот тогтоолыг батлав. Тогтоолд, "Нэгд, Тус хорооны 2023 оны 106 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын 4.5 дэх хэсгийг хүчингүй болгосугай. Хоёрт, Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга Г.Чинзориг/-д үүрэг болгосугай." гэжээ. ХХЗХ-ны Даргын 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 01/1418 албан тоотоор ХЗДХЯ-нд хянуулан бүртгүүлэхээр хүргүүлсэн ба тус яамны Сайдын 2025 оны 1/749 албан тоотоор (2025-08-12) тогтоолын холбогдох хэсгийг хүчингүй болгож, тогтоолын дагуу Улсын бүртгэлд хөдөлгөөн (ХЗДХЯ: Бүртгэлийн дугаар 6452) хийсэн болно.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль УИХ-аар 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр соёрхон батлагдаж, 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн ба энэхүү хуулиар Олон нийтийн болон төлбөртэй радио телевизийн үйлчилгээнээс бусад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох болсонтой холбогдуулан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7.б дэх заалтыг үндэслэн "Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам"-ыг тус Хорооны 2020 оны 64 тоот тогтоолоор; түүнчлэн "Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг"-ийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 90 дүгээр тогтоолоор баталсан болно. Зөвшөөрлийн тухай хууль 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр батлагдаж, 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн ба уг хуулийн 5.6 дугаар зүйлийн 1¹-д өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох, 2²-т тусгай зөвшөөрлийг олгох харилцааг тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулна гэж заасан ба түүнтэй холбогдуулан Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр нэмэлт оруулж, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын зарчим, тавигдах нөхцөл, шаардлагыг шинэчлэн батлан мөрдөж байна. Иймээс хорооны 2025 оны ээлжит 14 дүгээр хуралдаанд ӨНЗГ, ЗУХАГ, Хуулийн хэлтсээс хамтран өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтыг дээрх хуулиудад нийцүүлэн тогтоолыг цуцлах шаардлагатай гарсан тул "Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг" баталсан (Хорооны 2020 оны 90 тоот тогтоол) тогтоолыг цуцлах тухай үндэслэл танилцуулга, тогтоол цуцлах тухай тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлэв. Тус хуралдаанаар Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 140 тоот "Тогтоол цуцлах тухай"

¹ 1.Энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.8, 1.15, 1.23, 1.24, 1.25, 1.29 дэх заалт, 6 дахь хэсгийн 6.12 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар, 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.18 дахь заалт, 5 дахь хэсгийн 5.1 дэх заалт, 8 дахь хэсгийн 8.14, 8.28, 8.29 дэх заалт, 9 дэх хэсгийн 9.2, 9.6, 9.7, 9.8, 9.9, 9.10, 9.11 дэх заалт, 11 дэх хэсгийн 11.1, 11.9, 11.12 дахь заалт, 12 дахь хэсгийн 12.1, 12.2, 12.14 дэх заалтад заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгоно.

² 2.Энэ зүйлийн 1-д заасан журмаар зөвшөөрлийг олгох харилцааг тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулна.

тогтоолыг баталж, тус хорооны “Жишиг баримт бичиг батлах тухай” 2020 оны 90 дүгээр тогтоолыг цуцлан шийдвэрлэсэн болно.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдаж, 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Харилцаа холбооны зохицуулах хороо Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан 12 зохицуулалтын баримт бичиг, сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ (тус Хорооны 2021 оны 25 дугаар тогтоол) болон сонгон шалгаруулалтын эрхийн төлбөрийн хэмжээ (тус Хорооны 2021 оны 26 дугаар тогтоол)-г Хорооны тогтоолоор баталж, мөрдөн ажиллаж байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн ... 9 дэх хэсгийн 9.2, 9.6, 9.7, ..., 9.9, ... дэх заалт, ... заалтад заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгоно” гэж, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7-р зүйлийн 7.4.5-д “Энэ хуулийн 6.1.3, 6.1.6-д зааснаас бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах” гэж, 30 дугаар зүйлийн 30.1.9-д “өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог тогтоох” гэж тус тус хуульчилсан. Энэ хүрээнд тус Хорооны 2020 оны 91 дүгээр тогтоол (2021 онд олгох), 2021 оны 71 дүгээр тогтоол (2022 онд олгох), 2023 оны 35 дугаар тогтоол, 2024 оны 114, 181, 211 дүгээр тогтоол, 2025 оны 115 дугаар тогтоолоор тус тус нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоож, тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Харилцаа холбооны тухай хуулийн 9-р зүйлийн 9.1.11, 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам” (*Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/42 дугаар тушаал*)-ын 2.7-д “Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгосон тохиолдолд сонгон шалгаруулалтын эрхийн төлбөрийг Харилцаа холбооны зохицуулах хороо тухай бүр тогтооно” гэж заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Сонгон шалгаруулалтын эрхийн төлбөр” тогтоох тухай 2021 оны 26 дугаар тогтоолыг батлан мөрдөж байна. Харилцаа холбооны зохицуулах хороо зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулах талаар 2021 оноос холбогдох судалгааг гүйцэтгэж 2024 онд Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас зөвлөх үйлчилгээ авч, өгсөн зөвлөмж, боловсруулсан аргачлалын дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд тооцоолол, судалгаа хийж тус Хорооны 2024 оны 203 тоот тогтоолоор зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулсан бөгөөд тогтоолыг 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Тус Хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль тогтоомжоор хүлээсэн өрсөлдөөн, хэт төвлөрлийн зохицуулалт хийх, радио, телевизийн хөтөлбөрт байнгын хяналт, мониторинг хийх, тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллах онцлог зохицуулалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Түүнчлэн сонгууль, хүүхэд хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах зэрэг бусад үйлчилгээнээс ялгаатай зохицуулалтын арга хэмжээг авч ажиллаж ирсэн билээ. Хорооны 2025 оны ээлжит 14 дүгээр хуралдаанд ӨНЗГ, ЗЗҮТЗГ, ЗУХАГ, Хуулийн хэлтсээс хамтран өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулах, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулсан тогтоол шийдвэр, бусад хууль тогтоомжид нийцүүлэн тогтоолыг цуцлах шаардлагатай болсон тул “Сонгон шалгаруулалтын эрхийн төлбөрийн хэмжээ тогтоох тухай” (Хорооны 2021 оны 26 тоот тогтоол) тогтоолыг

цуцлах тухай үндэслэл танилцуулга, тогтоол цуцлах тухай тогтоолын төслийг тус тус боловсруулан хэлэлцүүлсэн болно. Энэхүү хэлэлцсэн асуудлаар, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 141 тоот “Тогтоол цуцлах тухай” тогтоолыг баталж, тус хорооны “Сонгон шалгаруулалтын эрхийн төлбөр” тогтоох тухай 2021 оны 26 дугаар тогтоолыг цуцлан шийдвэрлэв.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 14 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, тусгай зөвшөөрөл дугаарлалтын хугацаа сунгах тухай болгох тухай үнэлгээ, дүгнэлт болон Бүртгэлийн гэрчилгээ хүчингүй болгох тухай, Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 8 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 8 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 142 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 3 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 143 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 2 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар (Бат сүлжээ ХХК; Таэкванг кэй эйч ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 144 тоот тогтоолыг баталж, тогтоолоор Скаймедиа корпораци ХХК-ийн Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх” 14500005 тоот тусгай зөвшөөрөл болон энэхүү зөвшөөрлийн хүрээнд ашиглагдаж буй 31200004, 31800002 тоот дугаарлалтын гэрээний хугацааг 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс 2030 оны 06 дугаар сарын 25-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаагаар тус тус сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 145 тоот тогтоолыг баталж, тогтоолоор Жимобайл нэт ХХК-ийн “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” 12100443 тоот тусгай зөвшөөрлийг 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс 2030 оны 07 дугаар сарын 03-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 146 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (МК транс ворлд ХХК, 43200074: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс—

БНСУ/; Англофрейт ХХК, 43200017 тоот: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс–АНУ/) 5 жилийн хугацаагаар сунгасан;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 147 тоот тогтоолыг баталж, тогтоолоор Сета тех ХХК-ийн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” 12800187 тоот тусгай зөвшөөрөл болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” 22800193 тоот тусгай зөвшөөрлийг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс 2030 оны 08 дугаар сарын 30-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 148 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 бүртгэлийн гэрчилгээг (Эрүүл мэндийн хөгжлийн төвийн “1800-0119” дугаарлалт бүхий 30010694 тоот тусгай дугаар ашиглах бүртгэлийн гэрчилгээг) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 149 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 харилцаа холбооны сүлжээний дугаарыг (Улсын хоёрдугаар төв эмнэлэг: 1800-0119) 2 жилийн хугацаатай шинээр олгон тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <https://crc.gov.mn/documents/xxzx-togtool> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-07-04